



ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 5-дугаар хавсралт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 15 дугаар тушаал, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 4.4.4 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын “Үйлчлэгчийн мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалт авах журам”-ыг нэгдүгээр, “Өрөө коридорын үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлт”-ийг хоёрдугаар, “Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлт”-ийг гуравдугаар, “Өрөө, коридорын үйлчлэгчийн заавал хийж дадсан байх ажилбарыг шалгах үзүүлэлт”-ийг дөрөвдүгээр, “Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн заавал хийж дадсан байх ажилбарыг шалгах үзүүлэлт”-ийг тавдугаар, “Өрөө, коридорын үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтийн хасагдах оноо”-г зургаадугаар, “Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтийн хасагдах оноо”-г долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг тухай бүр бэлтгэл сайтай зохион байгуулахыг Зохион байгуулалтын алба /Л.Адъяахүү/, Үйлчилгээний алба /Г.Бадам/-нд үүрэг болгосугай.


3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын даргын 2004 оны 38, 2005 оны 214 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Д.НЯМЖАВ

13 0077



ҮЙЛЧЛЭГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, АХИУЛАХ, МЭРГЭШЛИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ, ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Тус газрын үйлчлэгчийн мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалт авахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалт нь "Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээ ерөнхий шаардлага" CS11-0060:2009 /цаашид стандарт гэнэ/ байгууллагын стандартын дагуу цэвэрлэгээ үйлчилгээний мэргэшсэн ажилтанг бэлтгэх, ажлын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

1.3.Шалгалтад тус газрын бүх үйлчлэгчид хамрагдана.

1.4.Жирэмсний болон хүүхэд төрүүлсний дараах амралт, чөлөөтэй болон хүндэтгэх шалтгаантай ажилтныг өөрийнх нь хүсэлтээр шалгалтад оруулах буюу чөлөөлж болно.

1.5.Сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаж тушаалаар арга хэмжээ авагдсан ажилтанг шалгалтад оруулахгүй.

1.6.Энэхүү журмыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар болон түүний харьяа байгууллагуудад нэгэн адил дагаж мөрдөнө.

1.7.Тус газрын дэргэдэх сургалтын төвд үйлчлэгчийн мэргэжил эзэмшсэн үйлчлэгчдийн харьяалах байгууллагын хүсэлтээр мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулж болно.

Хоёр. Мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалтыг зохион байгуулах

2.1.Үйлчилгээний ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалтыг авахдаа стандартыг баримтлана.

2.2.Шалгалтыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын ерөнхий захирлын тушаалаар баталсан комисс зохион байгуулна.

